

**“ТҮМЭН ШУВУУТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР**

2022 оны 04 сарын 23-ны өдөр

№ 01/2022.

Улаанбаатар хот

*Компанийн жилийн үйл ажиллагааны болон
санхүүгийн тайлангийн талаархи
Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай*

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.11, 62 дугаар зүйлийн 62.1.9, “Түмэн шувуут” нээлттэй хувьцаат компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.9, 8.14 болон тус компанийн хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 02/2022 тоот тогтоолыг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ШИЙДВЭРЛЭХ нь:

1. “Түмэн шувуут” хувьцаат компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хавсралтаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Л.ЭРХЭМБАЯР

Түмэн шувуут ХК-ийн ХЭЭХ-ын хурлын
2022 оны 07 дүгээр сарын 23-ны өдрийн
01 дүгээр тогтоолын хавсралт

“ТҮМЭН ШУВУУТ” ХК-ИЙН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГӨХ ДҮГНЭЛТ

“Түмэн шувуут” хувьцаат компани 2021 онд 80.0 сая ширхэг өндөг үйлдвэрлэсэн нь өмнөх оныхоос 6,5%-иар өссөн бол тэжээлийн үйлдвэрлэл өмнөх онтой харьцуулахад 28,2%-иар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Компанийн голлох бүтээгдэхүүн өндөгний борлуулалтын орлого өмнөх онтой харьцуулахад 24.6%-ийн өсөлттэй байгаа бол малын тэжээлийн борлуулалт 230%-иар өссөн үзүүлэлттэй гарсан байна.

Үүнээс дүгнэхэд “Түмэн шувуут” ХКомпани нь 2021 онд 6.9 тэрбум төгрөгийн буюу 2020 онтой харьцуулахад 72.5%-ийн өсөлттэй ажиллажээ.

Дүгнэх нь: Үйлдвэрлэл нэмэгдэж борлуулалт өссөн нь компанийн цэвэр ашиг өсөхөд нөлөөлж байгаа төдийгүй цаг үеийн нөхцөл байдлаас гадна компанийн нэр хүнд, зах зээлд эзлэх байр суурь нэмэгдсэн. Түүнчлэн өвөлжилтийн хүндрэлтэй байдлаас үүссэн Засгийн газрын захиалгаар хийгдсэн тэжээлийн үйлдвэрлэл, ковидын цаг үед төрөөс авч хэрэгжүүлсэн гааль, НӨАТ, ашиглалтын зардлын хөнгөлөлтүүд нөлөөлсөн гэж үзэж байна.

Мөн 2021 онд нийт 700 тн органик бордоо үйлдвэрлэж 111 сая төгрөгийн борлуулалттай ажилласан байна. Үүнээс гадна СХД-ийн 21 дүгээр хороо, Их булагт байрлалтай шинэ шувууны аж ахуйд нэмж 3 байрыг ашиглалтад оруулан 15 ажилтан нэмж авсан нь 2021 оны үйлдвэрлэлийн тоог өсгөхөд тодорхой хувь нэмрээ оруулсан харагдаж байна. 2022 онд нэмж дэгдээхэйн болон өндөглөгчийн нийт 3 байрыг барьж ашиглалтанд оруулахаар төлөвлөжээ.

Дүгнэх нь: Органик бордооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхийн тулд төр, засгаас санаачлагатай “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрт оролцох, олон нийгэд таниулах, чиглэл, салбарын байгууллагууд /Уул уурхайн нөхөн сэргээлт, газар тариалан эрхлэгчид, хүлэмжийн аж ахуй эрхлэгчид/-тай хамтран ажиллах зэрэг ажлыг үе шаттай зохион байгуулан борлуулалтыг нэмэгдүүлэхэд зорьж ажиллах нь зүйтэй гэж үзэж байна.

“Түмэн шувуут” ХК-ийн санхүүгийн тайлан, мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, санхүүгийн баримт материалын бүрдэл, компанийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нийцүүлэн баталсан заавар, журам аргачлал, стандартын дагуу үнэн зөв тайлагнасан болохыг танилцуулж байна.

“Түмэн шувуут” Хувьцаат компанийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагааг хангалттай гэж дүгнэж, тус хувьцаат компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг ХЭЭХ-д танилцуулах нь зүйтэй гэж тогтов.

“ТҮМЭН ШУВУУТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛ

**“ТҮМЭН ШУВУУТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР**

2022 оны 04 сарын 23-ны өдөр

№ 02/2022.


Улаанбаатар хот

**Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
гишүүдийг сонгох тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 77 дугаар зүйлийн 77.4, “Түмэн шувуут” нээлттэй хувьцаат компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.7, 8.14 болон тус компанийн хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 04 дүгээр сарын 23-ний өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 03/2022 тоот тогтоолыг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчдээс хамгийн олон санал авсан дор дурдсан нэр дэвшигчдийг “Түмэн шувуут” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгосугай:
 - 1.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр:
 - 1.1.1. Ломбо овогтой Эрхэмбаяр;
 - 1.1.2. Балай овогтой Тунгалаг;
 - 1.1.3. Жигжид овогтой Болд;
 - 1.1.4. Эрхэмбаяр овогтой Баяржаргал;
 - 1.1.5. Эрдэнэчулуун овогтой Жаргалхүү;
 - 1.1.6. Болдбаатар овогтой Бархасбадь.
 - 1.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр:
 - 1.2.1. Цэдэв овогтой Наран-Учрал;
 - 1.2.2. Агипар овогтой Бакей;
 - 1.2.3. Гочоо овогтой Мөнх-эрдэнэ;
2. Хууль тогтоомж, компанийн дүрэм, компанийн засаглалын журмуудыг мөрдөж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нийт гишүүдэд үүрэг болгосугай.
3. ТУЗ-ын бүрэлдэхүүний талаарх олон нийтэд мэдээлж, шинээр сонгогдсон гишүүдийн мэдээллийг Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргэхийг Гүйцэтгэх захирал (Ж.Болд)-д үүрэг болгосугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Б.Нямбаяр/-т үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Л.ЭРХЭМБАЯР

**“ТҮМЭН ШУВУУТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР**

2022 оны 04 сарын 23-ны өдөр

№ 03/2022


Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны зардлын төсөв батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13, 62.1.15, “Түмэн шувуут” нээлттэй хувьцаат компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.13, 8.4.14 болон тус компанийн хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 02/2022 тоот тогтоолыг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ШИЙДВЭРЛЭХ нь:

1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны цалин урамшуулал, зардлын төсвийг хавсралтаар баталсугай.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах зардлыг санхүүжүүлэхийг Гүйцэтгэх захирал /Ж.Болд/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Л.ЭРХЭМБАЯР

Түмэн шувуут ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурлын 2022 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн
03/... тоот шийдвэрийн хавсралт
2022.



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН
ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХЭМЖЭЭ

ТУЗ-ийн гишүүд	Улиралд / тогтмол /төг/	Нэг удаагийн хуралд оролцоогоор /төг/
Ердийн гишүүд	500 000	300 000
Ердийн гишүүд	500 000	300 000
Ердийн гишүүд	500 000	300 000
Ердийн гишүүд	500 000	300 000
Ердийн гишүүд	500 000	300 000
Ердийн гишүүд	500 000	300 000
Ердийн гишүүд	500 000	300 000
Хараат бус гишүүд	500 000	300 000
Хараат бус гишүүд	500 000	300 000
Хараат бус гишүүд	500 000	300 000

“ТҮМЭН ШУВУУТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР

2022 оны 04 сарын 23-ны өдөр

№04/2022.

Улаанбаатар хот

Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.3, “Түмэн шувуут” нээлттэй хувьцаат компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.1 болон тус компанийн хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 02/2022 тоот тогтоолыг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ШИЙДВЭРЛЭХ нь:

1. Компанийн дүрмийн 9-р бүлэг 9.3 дугаар заалтад дараах байдлаар өөрчлөлт оруулсугай.
 - ТУЗ-ийн бүрэн эрхийн хугацаа 2 (Хоёр) жил байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 2 жилийн дараах хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах өдрөөр дуусгавар болох бөгөөд ТУЗ-ийн гишүүнийг хэдэн ч удаа улируулан сонгож болно.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж, хууль тогтоомжид заасан хугацаанд Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид холбогдох бичиг баримтыг хүргэх, дүрмийн өөрчлөлтийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал /Ж.Болд/ болон ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Б.Нямбаяр/-г үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Л.ЭРХЭМБАЯР